**МОНГОЛ УЛС**
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 21 өдөр Дугаар 109 Улаанбаатар хот

Хорооны 2007 оны 164
2009 оны 267 дугаар тогтоолын хавсралтад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 164 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1/ “ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

| № | Зохицуулалтын үйлчилгээний төрөл | Зохицуулалтын үйлчилгээний хөлс | |
|---|---|---|---|
| | | жил бүр /хувиар/ | нэг удаагийн /төгрөгөөр/ |
| 1 | Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах | | 10,000 |
| 2 | Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх | | 100,000 |

“.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох журам”-ын 3.2 дахь заалтад дор дурдсан агуулгатай нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1/ “3.2. Тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дараах байдлаар тогтооно:

| № | Хороонд төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний төрөл | Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/ | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|
| 1 | Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх | 200,000 | |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Дүрэм болон бусад өөрийн мэдээллийг Хорооны архиваас хуулбарлан нөхөн авах болон бусад үйлчилгээ үзүүлэхэд төлөх хөлс | 1,000 | Нэг нүүр хуудас |

“.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН